



МОНГОЛ УЛС
ДУНДГОВЬ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2023 оны 06 сарын 23 өдөр

Дугаар А/973

Мандалговь

Газар эзэмших эрхийн гэрчилгээг
хүчингүй болгох тухай

Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1, Газрын тухай хуулийн 40 дүгээр зүйлийн 40.1.5, 40.1.6 дахь заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Сайнцагаан сумын 7 дугаар багийн нутаг дэвсгэр хангамжийн хашааны баруун талд байршилтай Сайнцагаан сумын Засаг даргын тамгын газар (РД:9033556)-ний цэцэрлэг барих зориулалттай 9500 м.кв (0,9га) газрын эрхийн гэрчилгээ эзэмшигч газрын төлбөрөө хугацаанд нь төлөөгүй, мөн хүндэтгэн үзэх шалтгаангүйгээр гэрээнд заасан зориулалтын дагуу тухайн газраа 2 жил дараалан ашиглаагүй байгаа тул газар эзэмших эрхийг хүчингүй болгосугай.
2. Дээрх байгууллагын газар эзэмших гэрээг цуцалж, гэрчилгээг хүчингүй болгохыг Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газарт үүрэг болгосугай.
3. Энэ захирамж гарсантай холбогдуулж аймгийн Засаг даргын 2014 оны А/564 дугаар захирамжийн Сайнцагаан сумын Засаг даргын тамгын газар-т холбогдох хэсэг мөн газар эзэмших 000435677 тоот гэрчилгээг тус тус хүчингүй болсонд тооцсугай

ЗАСАГ ДАРГА



Ц.МӨНХБАТ

4822100987